



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/760

Булган сум

Орос хэлний багшийн байрны түрээсийн зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.4.1, аймгийн Засаг даргын А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны яам болон Оросын Холбооны Улсын төсвийн ерөнхий боловсролын байгууллага Е.Д.Стасовагийн нэрэмжит “Интердом” олон улсын боловсролын төв хоорондын гэрээгээр Ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд ажиллах Орос хэлний багшийн байрны түрээсийн зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Байрны түрээсийн зардалд шаардагдах 2,800,000 (хоёр сая найман зуун мянга) төгрөгийг “Шинэ Багш” хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ